



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2021 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 229

Улаанбаатар хот

Дуудлагын худалдаа зохион байгуулах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Архангай аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 20,000,000.00 (хорин сая) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Архангай аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга Ч.Отгонжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Архангай аймгийн Орон нутгийн өмчийн газраас төлөөлөгч оролцуулан үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу (дуудлага худалдааны зардлыг хассан дүнгээр) улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Худалдсан автомашины улсын дугаарыг шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001540

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн  
289 ... дугаар тогтоолын хавсралт

**АРХАНГАЙ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ  
АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

| Д/д      | Автомашины марк,<br>улсын дугаар, арлын<br>дугаар | Гүйлт      | Үйлдвэрлэсэн,<br>ашиглалтад<br>орсон огноо | Баласнын үнэ,<br>хуримтлагдсан<br>элэгдэл | Дуудлагаар<br>худалдах доод<br>үнэ |
|----------|---|------------|--|---|------------------------------------|
|          |   | (км)       |  | (төгрөг)                                  |                                    |
| 1        | Тоёото Ландкрузер 80,<br>00-61 АРХ, НZJ810002176  | 584,869.00 | 1993/2001                                  | 20,000,000.00                             | 2,000,000.00                       |
| Нийт дүн |   |            |  | 20,000,000.00                             | 2,000,000.00                       |
|          |   |            |  | (хорин сая)                               | (хоёр сая)                         |